



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№105 /549/

2023.07.03

Цаг үе, үйл явдал

НҮБ-ЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ЦЭРГИЙН ЗӨВЛӨХ МОНГОЛ УЛСАД АЛБАН ЁСНЫ АЙЛЧЛАЛ ХИЙЖ БАЙНА



Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргын цэргийн зөвлөх генерал Бирами Диоп Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын урилгаар манай улсад албан ёсны айлчлал хийж байна.

Түүнийг Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба тэргүүтэй БХЯ, ЗХЖШ-ын удирдлагууд хүлээн авч уулзсан юм.

Уулзалтаар Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчдын Энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй өнөөгийн байдал

болон цаашдын оролцоо, ач холбогдлын талаар санал солилцов.

Айлчлалынхаа хүрээнд тэрээр Зэвсэгт хүчний 337, 350 дугаар ангиудад ажиллаж зэвсэглэл, техник, ангийн өдөр тутмын үйл ажиллагаатай танилцав.

Түүнчлэн "Хаан күэст-2023" энхийг дэмжих ажиллагааны олон улсын хамтарсан сургуулийн хүрээнд зохион байгуулсан бэсрэг наадмыг үзэж сонирхов. Бэсрэг наадмын хүрээнд ноён Бирами Диоп ЦДБЭЧ-ын уран бүтээлчдийн бэлтгэсэн уртын дуу, ардын бүжгийг үзэж сонирхсоны

зэрэгцээ малчин айлд зочилж, монгол ахуй соёлтой танилцав.

Мөн Монголын анхны төрт улс Хүннү эзэнт улсаас эхлэн монголчуудын төрт ёсны голомт XX зуунд хэрхэн дахин сэргэсэн хүртэлх цаг үеийг бүрэн харуулсан Чингис хаан үндэсний музейгээр аялж эртний төрт улсуудын хаад язгууртны он дараалал, тухайн цаг үеийн нүүдэлчдийн эдэлж хэрэглэж байсан зүйлс, хувцас эдлэл хэрэглэл зэрэг бодит эд өлгийн зүйлсийг үзэж сонирхлоо.

Дэслэгч
Ө.НАСАНТОГТОХ



Д.Ганхуяг: ХУРДАН МОРИНЫ ШҮДЭЛГЭЭНИЙ ҮЙЛ ЯВЦЫГ ОРОН ДАЯАР ШУУД ДАМЖУУЛНА



байгуулах хороо нь есөн салбар хороотой, нийт 218 хүн ажиллаж байна. Ямар нэгэн алдаа дутагдал гарахаас сэргийлж зохион байгуулалтын өндөр түшинд ажиллаж байгаа" гэв.

Наадмын тасалбарыг хоёр дахь жилдээ цахимаар худалдаж байна. Ирэх 7 дугаар сарын 1-ний өдрөөс enaadam.mn-ээр худалдаж эхлэхээр бэлтгэл ажлыг хангаж буй. Баяр наадмын тасалбар нь эрэлт ихтэй байдагтай холбогдуулан энэ жил серверийг өндөр түвшинд өргөтгөн бэлтгэсэн. Түүнчлэн банк болон бусад төлбөрийн системүүдийн ачааллыг бууруулах зорилгоор төлбөр төлөх хугацааг уртасган нэмэлт хөгжүүлэлт хийсэн гэдгийг Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооноос мөн онцлолоо.

Энэ үеэр Хурдан морины салбар хорооны дарга, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг ажлын явцын талаар мэдээлэл өгсөн юм.

Тэрээр "ХХААХҮЯ болон мэргэжлийн морин спортын холбоод хамтран бүртгэлийн санг хуулийн дагуу 2025 оны 6 дугаар сараас өмнө бүрдүүлэх ёстой. Түүнээс өмнө хурдан морьдын уралдааныг Засгийн газрын тогтоолоор батлагдсан дүрмийн дагуу зохион байгуулж байна. Энэ жил мөн тус дүрмийг барьж ажиллана. Энэ удаагийн Үндэсний их баяр наадмаар долдугаар сарын 10-12-нд зургаан насны морь уралдана. 13-нд эрлийз, дээд, дунд, бага, жороо морины уралдаан зохион байгуулагдана. Өмнө жил сэрвээний өндрийг хэмжих үйл явцыг орон даяар шууд дамжуулсан. Энэ жил шүдэлгээний хэсгийг камержуулж, үйл явцыг орон даяар шууд дамжуулахаар төлөвлөж, бэлтгэл ажлыг хангаад байна. Наадмын талбай дахь хурдан морины уралдах замыг очиж үзсэн. Хур тунадас, цаг агаарын байдлыг ажиг, дөхүүлж байгаад зам засна.

Өнгөрсөн жил уяачид мориныхоо сэрвээг шивэх, туурайг нь хуурайдах зэрэг зөрчил цөөнгүй гаргасан байсан. Ийм зөрчил дахиж гаргалгүй сайхан наадахыг уриалж байна" гэсэн юм.

Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооноос Наадмын зохион байгуулалт, төлөвлөлтийн талаар мэдээлэл өглөө.

Энэ жилийн Үндэсний их баяр

наадмын бэлтгэл өмнөх жилүүдийнхээс эрт эхэлсэн тул 80 хувьтай байна хэмээн тус хорооны Нарийн бичгийн дарга И.Баатархүү эхэнд нь хэллээ. Мөн "Үндэсний их баяр наадмыг зохион

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
13	10

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
33	23

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,432	3,438
EUR	3,742	3,755
CNY	477	479
RUB	38.30	38.80
JPY	23.95	24.15
KRW	2.60	2.62

ЗУРХАЙ

2023.07.04 /МЯГМАР ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 16

ЗУНЫ ДУНД ШАР МОРЬ САР
ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ
ХАРАГЧИН ГАХАЙ ӨДӨР

ҮС ЗАСУУЛБАЛ:

ӨВЧИН ИРНЭ

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

04.59-20.54

БАРИЛДЛАГА:

Түлэх

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

Хүрэлцэхүй

Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Эл өдөр шатаахын учралтай тул зовлонтой, цэрэг татах дайсанаа дарах хатуу үйлийг үүсгэвээс зохистой, хараал дарах, гал мандал хий зэрэгт сайн. Баруун нүд татвал эд олох, баруун чих хангинавал аймшиг болох, зүүн чих жингэнэвэл жуулчин ирэх, хэрээ дуугарвал зочин ирэх, тагнай загатанал амгалан болох, бие татвал эцэг эх цочих, хөл татвал тэмцэл болно.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 690,985,963

Эдгэрсэн

Нийт: 663,652,817

Нас барсан

Нийт: 6,896,160

Цахим шууданд

МОНГОЛЫН ЗЭВСЭГТ ХҮЧИН 200 ГАРУЙ ДЭД АХЛАГЧААР ХҮРЭЭГЭЭ ТЭЛЛЭЭ



Цэргийн мэргэжлийн ахлагч бэлтгэх сургалтад хамрагдсан Зэвсэгт хүчний 30 гаруй нэгтгэл, ангийн 200 гаруй цэргийн гэрээт болон хугацаат албаны дайчид сургалтаа амжилттай дүүргэж, өнөөдөр дэд ахлагч цолоо гардаж, Монголын Зэвсэгт хүчний ахлагчийн эгнээнд нэгдлээ.

Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн "Ахлагчийн хөгжлийн төв"-ийг түшиглэн зохион байгуулагдсан уг сургалт Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлд хоёр сарын хугацаанд үргэлжилсэн бөгөөд өнөөдөр болсон төгсөлтийн үйл ажиллагаанд Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга бригадын генерал С.Ганбямба, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч бригадын генерал Ч.Цогтжаргал, ЗХЖШ-ын ахлагч, тэргүүн ахлагч Н.Баасан, УБХИС-ийн Сургалтын хэлтсийн дарга хурандаа Б.Батмөнх, Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн захирал хурандаа Ж.Мөнхбаяр нарын удирдлагууд болон төгсөгчдийн ар гэрийн төлөөлөл оролцсон юм.

Төгсөлтийн баярыг хурандаа Ж.Мөнхбаяр нээж хэлсэн үгэндээ "Яг хоёр сарын өмнө сургалтад хамрагдахаар өөр өөрийн ангиасаа хүрэлцэн ирж байсан та бүхэн өнөөдөр ахлагчийн албанд нэгдэхээр баяртайгаар зогсож байна. 200 гаруй цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдын цэргийн ерөнхий бэлтгэлийг бататган, богино хугацааны эрчимжүүлсэн сургалтаар "Буудагч" мэргэжил эзэмшүүлж, чадамжийн гэрчилгээтэй ахлагчийг төгсгөж байгаадаа баяртай байна. Та бүхэн суралцах хугацаандаа цэргийн хэргийн мэдлэг, чадварыг эзэмшихээс гадна эдүгээ 100 жилийн ойтойгоо золгож байгаа Монгол Улсын маршал Х.Чойбалсангийн нэрэмжит Сүхбаатарын болон Байлдааны гавьяаны Улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлд хэсэгхэн ч гэсэн саатаж суралцсанаа хэзээд дурсаж, бахархаж яваарай" гэж амжилт хүслээ.

ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба төгсөгчдөд баяр хүргэхийн ялдамд "Монгол Улсын Үндсэн хуульд заасан эрхэм үүргийнхээ дагуу өөрийн хүсэлтээр ахлагчийн албанд элсэж байгаа та бүхнээрээ бахархаж байна. Зэвсэгт хүчин хэмээх их айлын нэгэн гишүүн болж байгаа та бүхэн цаашдаа улам хариуцлагатай байж, өргөсөн тангарагтаа үнэнч байж, албаныхаа нэр хүндийг өндөрт



өргөж явна гэдэгт эргэлзэхгүй байна. Мөрдэстэй бүхнээс Зэвсэгт хүчний алдар суу, нэр хүнд хамаарч байдгийг ухамсарлаж явахыг захъя. Цэл залуухан 200 гаруй ахлагчаар эгнээгээ тэлсэндээ баяртай байна. Идэр сайхан залуусыг эх орныхоо төлөө зүтгэхийг харах сайхан байна" гэсэн бол төгсөгчдийн ар гэрийнхэнд Зэвсэгт хүчинтэйгээ ойрхон байж, цэрэг дайчдаа хүндэтгэж явдагт нь талархал дэвшүүлэв. Энэхүү эрчимжүүлсэн сургалтыг Зэвсэгт хүчний ХЗЦК-аас мэргэжлийн удирдлагаар хангаж, нэгтгэлийн ахлагч тэргүүн ахлагч Н.Энхбаатар тэргүүтэй ахлагчдын бүрэлдэхүүн удирдан явуулсан бөгөөд төгсөгч дэд ахлагч нар Зэвсэгт хүчний нэгтгэл ангиудад буудагч, харуул, хөгжмийн албан тушаалд томилогдон ажиллах юм.



Төгсөгчдөд баяр хүргэж, цол гардуулах ёслолын үеэр ахлагчид ая дууны мэндчилгээ өргөж, гардан тулааны үзүүлбэр үзүүлж, төгсгөлд нь ар гэрийн төлөөлөл талархал илэрхийллээ. Бид уг төгсөлтийн баярын үйл ажиллагааны үеэр удирдлагын бүрэлдэхүүн, төгсөгчид болон тэдний эцэг эхийн төлөөлөлтэй уулзаж санал сэтгэгдлийг нь сонслоо.

Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч бригадын генерал Ч.Цогтжаргал:

- Монгол Улсын аюулгүй байдал, эх орноо батлан хамгаалах үйлсийн хамгийн үнэт зүйл болсон мэргэжлийн ахлагчдын эгнээ өнөөдөр 200 гаруй сайхан залуугаар хүрээгээ тэллээ. Мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчний үндэс суурь нь мэргэжлийн ахлагчид бөгөөд хамгийн хүнд хэцүү, ачааны хүндийг эд маань үүрнэ. Эх орныхоо амар амгалан, сайн сайхны төлөө тэд тангарагтаа үнэнч зүтгэнэ. Өнөөдрөөс ахлагчийн эгнээнд орж, маргаашнаас ажил албандаа томилогдох төгсөгчид маань тун удахгүй дэлхийн халуун цэгт энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэнэ. Шинээр ахлагчийн эгнээнд орж байгаа алба хаагчдаа амжилт хүсье.



Сонгинохайрхан дүүргийн иргэн Г.Гэрэлт-Од:

- Би дэд ахлагч Г.Билгүүнтөгсийн аав. Миний хүү өөрийн хүсэлтээр хугацаат цэргийн албанд мордсон, өнөөдөр ингээд ахлагчийн эгнээнд элсэн орж байгаад аавын хувьд маш их бахархаж байна. Цэргийн алба гэдэг эх орныхоо төлөө, өөрийн амьдрал, ирээдүйнхээ төлөө хийж байгаа чухал алхам. Тэгээд үргэлжлүүлэн ахлагч болно гэдэг асар их хариуцлага гэж бодож байна. Домогт арван баатар төрүүлсэн бахархам түүхтэй энэ ангид миний аав ажиллаж байсан, миний бага нас энд өнгөрсөн. Гэтэл хүү маань энд алба хаасан төдийгүй эндээс ажил амьдралын гараагаа эхэлж байгаад бүр ч их баяртай байна. Хүүдээ амжилт хүсье ээ.

Дэд ахлагч Ц.Ууганбаяр:

Зэвсэгт хүчний 120 дугаар ангид хугацаат цэргийн албанд татагдсан. Мэргэжлийн ахлагч бэлтгэх төвийн анхны төгсөгчдийн нэг болсондоо баяртай байна. Энэ бол нэр төрийн хэрэг. Зэвсэгт хүчний бүрэлдэхүүний 80 гаруй хувийг ахлагчид эзэлдэг. Ахлагч гэдэг үгнээсээ л утга агуулга нь тодорхой. Бусдыг ахалж, манлайлж, бусдын тэргүүнд байх утгатайг ойлгосон болохоор их үнэ цэнэтэй санагдаж байгаа. Миний өвөө цэргийн хүн байсан болохоор би багаасаа л цэргийн анги, цэргийн амьдралд ойр өссөн, дотно санагддаг. Тиймээс цаашдаа хариуцсан ажил албандаа үнэнч зүтгэж, олон улсын энхийг сахиулах ажиллагаанд оролцож, монгол цэргийн сүр хүчийг гайхуулсан үйлсэд нэгдэж, алсдаа сайн тэргүүн ахлагч болох зорилготой. Энд байгаа залуус тал бүрээр өөрийгөө хөгжүүлдэг. Миний хувьд Мэргэжлийн ахлагч бэлтгэх төвийнхөө сүлд дууг зохиож, сая төгсөлтийн баяраараа дууллаа. Эрэлхэг хөвгүүдийн эгнээ жигдхэн Эрчилсэн сум мэт зорилго нэгтгэнэ. Эх орны хүү болохоор сэтгэл зорьсон Эрэмгий хурц ухаант ахлагч болсон... гэж дуулахдаа өөрийн эрхгүй огшсон.

"ОЮУТАН ЦЭРЭГ" СУРГАЛТЫН НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ БОЛОВ



Оюутан цэргийн мэргэжлийн боловсрол олгох сургалтын хэргийн гаралтыг зохион байгуулаад хагас сарын хугацаа өнгөрлөө. Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаярын үүрэг чиглэлийн дагуу "Оюутан цэрэг" сургалтын нээлттэй өдөрлөгийг өнөөдөр Шархадны сургалтын төв болон Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн Сургалтын төвд зохион байгуулав.

Өдөрлөгт Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний удирдлагууд, тус сургалтын хэргийн гаралтыг зохион байгуулагчид болон оюутан цэргүүдийн эцэг эх, ахан дүүс, найз нөхдийн төлөөлөл оролцлоо.

Энэ үеэр оюутан цэргүүд богинохон хугацаанд ихийг сурч мэдсэнээ эцэг эхчүүддээ сонирхуулж, урлагийн хэсэгчилсэн тоглолт, мэндчилгээ, дасгал сургуулийн үйл явцаасаа үзүүлсэн юм. Оюутан цэргүүдийн дунд урлаг, спорт, оюуны өндөр чадамжтай залуус олон байдаг талаар сургалтын төвийнхөн өгүүллэн.

Нээлттэй өдөрлөгийн төгсгөлд оюутан цэргүүдийн ар гэрийнхэнд хэргийн сургалт хэрхэн явагдаж байгаа орчин нөхцөл, хичээлийн цэгүүд, хоолны амт чанар байдалтай бодитоор танилцах боломж олголоо.

Л.ДАНДАРЫН "ЦЭРГҮҮД" СОНСОГЧ ҮЕЭ ДУРСЛАА



Нэгэн жарны өмнө хойд хөршийн цэргийн их дээд сургуульд суралцахаар хамтдаа эх орноосоо мордож байсан офицер, ахлагч, байлдагчид өнөөдөр Офицеруудын ордонд хуран чуулж, бэлтгэлд байгаа дэд хурандаа Б.Жамьянсүрэнгийн эрхлэн хэвлүүлсэн "БНМАУ-ын гарамгай баатар Л.Дандарын хариуцсан ЗХУ-д суралцах цэргийн цувааны офицер, дайчдын гэрэл зургийн цомог-1965" номын нээлтэд оролцлоо.

Жараад оны дунд үеэс Монголын Ардын Армийг өргөтгөн зохион байгуулах зайлшгүй шаардлага тулгарсан бөгөөд нэр их ажил, хөрөнгө шаардсан үйлс болжээ. Монгол Улсын Зэвсэгт хүчний түүхэнд цоо шинэ цэргийн шинэчлэл хийсэн гурав дахь үе шат болсон бөгөөд цэргийн нэгтгэл ангиудыг нэмж байгуулах, шинээр төрөл мэргэжлийн цэргийг үүсгэн байгуулах хэрэгцээтэй шууд уялдан цэргийн боловсон хүчнийг олон тоогоор сургаж бэлтгэх шаардлагатай болсон. Энэ хэрэгцээг хангах зорилгоор анх удаа ЗХУ-ын цэргийн академи, дээд, дунд сургуулиудад хамгийн олон буюу 198 хүнийг илгээжээ.

Тэдгээр алба хаагчдын 52 нь өнөөдөр эсэн мэнд амьдарч байгаа

бөгөөд тэд эдүгээгээс 58 жилийн өмнөх гадаадад их дээд сургуульд суралцахаар эх орноосоо мордож байсан өдрөө эргэн санаж, цэл залуухан хориодхон насныхаа гэрэл зургийг харж сэтгэлээ сэргээхийн зэрэгцээ Монголын Зэвсэгт хүчний цэргийн дүрэмт хувцасны түүхэн хөгжил, гадаадад суралцаж байх үеийн түүхэн гэрэл зургууд, цувааг ахлах явсан "алаг морьт" Л.Дандар баатрын амьдралын түүхэн хормууд, эдгээр онжавын дундаас төрсөн эрхэм генералуудын талаар гэрэл зураг, мэдээлэл бүхий номыг хүндэтгэлтэйгээр гардан авлаа. Мөн Батлан хамгаалах яамаар орж, өөрсдийн ажиллаж байсан өрөөгөөрөө зочлохын зэрэгцээ Хар сүлдний өргөөгөөр орж, хүндэтгэл илэрхийллээ.

Ташрамд дурдахад, уг номын зохиогч бэлтгэлд байгаа дэд хурандаа Б.Жамьянсүрэн 1965-1980 онд Киев хотын С.М.Кировын нэрэмжит Артиллерийн инженерийн дээд сургууль, команд штабын мэргэжлээр төгссөн нэгэн бөгөөд БХЯ, ЗХЖШ, УИХЕГ зэрэг батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги байгууллагуудад штабын дарга, командын байрны дарга, Шуурхай албаны офицероор ажиллаж байжээ.